



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А.344

Номгон

Өвс, тэжээлийн үнэ хямдруулж, худалдан
борлуулах, хөнгөлж чөлөөлж тусламж
үзүүлэх, Урлон тэжээл
актлах тухай

Аймгийн хэмжээнд зуншлага тааруу байсны улмаас өвөлжилт, хаваржилт хүндэрч, малчдадаа туслах, хүнд хэцүү үед нь дэмжлэг туслалцаа болох үүднээс Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн “а, б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.6 дахь заалт аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 35 тоот хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

1.Аймгийн аюулгүйн нөөцөөс Заг сумд байршуулсан 2200 боодол өвс, Баяновоо сумд байршуулсан 2315 боодол өвсийг тус бүрийн үнэ 6200 төгрөгөөр үнэ хямдруулан худалдан борлуулах, аймгийн аюулгүйн нөөцөд байгаа 500 кг-тай 101 ширхэг урлон ногоон тэжээлийн үлдэгдлийн 1 бүрийн үнийг 100,000 төгрөгөөр худалдан борлуулах, Өлзийт сумд байршуулсан урлон ногоон тэжээлийн үлдэгдэл 38 ширхэг тус бүрийн үнийг хямдруулж 100 мянган төгрөгөөр борлуулах ажлыг Сум дундын Ойн анги, орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар (П.Уртнасан), Заг сумын Засаг дарга (Н.Нямжаргал), Баяновоо сумын Засаг дарга (Ж.Хатанбаатар)-т нарт үүрэг болгосугай.

2.Аймгийн аюулгүйн нөөцөөс Баянговь сумд байршуулсан 72 ширхэг 500 кг-тай Урлон ногоон тэжээлээс 58 ширхэг Урлоныг Жаргалант сумд, Мөн Баацагаан суманд байршуулсан аюулгүйн нөөцийн, хямдарсан үнээр 7500 төгрөгний үнэтэй 200 боодол өвсийг, цас их хэмжээгээр орж нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан тус сумдуудад тусламжаар олгохыг, Эрдэнэцогт сумд байршуулсан аюулгүйн нөөцийн ногоон тэжээлээс хямдарсан үнээр 7500 төгрөгний 81 ширхэг ногоон тэжээл, мөн хямдарсан үнээр 8900 төгрөгний 839 ширхэг ногоон тэжээл, нийт 920 ширхэг ногоон тэжээлийн нийтэд нь 7000 мянган төгрөг болгон хямдруулан


621010875

тооцож үнийг төвлөрүүлэхийг Сум дундын Ойн анги орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар (П.Уртнасан)-д даалгасугай.

3.Иргэдийн худалдан авсан Урлон ногоон тэжээл нь “хөгцөрсөн, мал идэх боломжгүй байна” гэсэн малчид, мал бүхий иргэд сумдаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн хавсралтаар баталж, акталж устгалд оруулах ажлыг Сум дундын Ойн анги орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар (П.Уртнасан)-д үүрэг болгосугай.

4.Аймгийн төвд төл мал тэжээж онд оруулсан аж ахуйн нэгж, албан байгууллагуудаас өвс, тэжээлийн авлага болох 13,636,750 төгрөгийг хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулахыг Сум дундын Ойн анги орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар (П.Уртнасан)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигтбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 он 06 дугаар сарын 02-ны
 өдрийн А/344 дүгээр захирамжийн хавсралт



**ХУРНИАД ХХК-НААС НИЙЛҮҮЛЭГ ДӨНН 500 КГ ТАЙ
 НОГООН ТЭЖЭЭЛИЙГ АКТАЛЖ, УСТГАЛД ОРУУЛАХ ЖАГСААЛТ**

№	Сумдын нэрс	Буусан тоо /ш/	Борлуулагдсан тоо /ш/	Хөгцөрч муудсан актлагдах Урлоны тоо /ш/
1	Өлзийт	53	53	0
2	Бөмбөгөр	37	30	7
3	Бууцагаан	40	36	4
4	Хүрээмарал	30	29	1
5	Жинст	50	50	0
6	Богд	60	54	6
7	Баяновоо	60	60	0
8	Галуут	60	53	7
9	Баянлиг	76	33	43
10	Баянговь	72	68	4
11	Баянбулаг	30	24	6
12	Аймгийн төвд	432	415	17
	Нийт дүн	1000	905	95

-----oOo-----